



**ӨВӨРХАНГАЙ АЙМГИЙН
ЗАСАГ ДАРГЫН ЗАХИРАМЖ**

2019 оны 01 сарын 24 өдөр

Дугаар А/35

Арвайхээр

**Сумын Засаг даргын Тамгын газрын 2018 оны
үйл ажиллагааны үр дүнд хийсэн хяналт-шинжилгээ,
үнэлгээний дүнгийн тухай**

Аймгийн Засаг даргын 2017 оны а/552 дугаар захирамжаар батлагдсан “Бодлогын баримт бичгийн хэрэгжилт, нутгийн захиргааны байгууллагын үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх журам”-ын 11 дүгээр зүйлийн 11.1 дэх заалтыг үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Сумын Засаг даргын Тамгын газрын 2018 оны үйл ажиллагааны үр дүнд хийсэн хяналт-шинжилгээ, үнэлгээний дүнгээр Баянгол, Хайрхандулаан, Арвайхээр, Хархорин, Есөнзүйл сумдыг тэргүүний сумаар шалгаруулж, тус бүр 1.500.000 (нэг сая таван зуун мянга) төгрөгөөр шагнасугай.

2. Шагналын зардалд шаардагдах нийт 7.500.000 (долоон сая таван зуун мянга) төгрөгийг батлагдсан зардлаас гаргахыг Засаг даргын Тамгын газар (Ц.Ганболд)-т зөвшөөрсүгэй.

3. Үйл ажиллагааны үр дүнгээр тэргүүлсэн Баянгол, Хайрхандулаан, Арвайхээр, Хархорин, Есөнзүйл сумдын Засаг дарга, Засаг даргын Тамгын газрын дарга нарт нэг сарын үндсэн цалинтай тэнцэх хэмжээний мөнгөн урамшууллыг тухайн байгууллагын төсвөөс олгохыг нягтлан бодогч нарт зөвшөөрсүгэй.

ЗАСАГ ДАРГА



Г.ГАНБОЛД

011100093